

**“НООЛУУР” ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2019 оны 03 дугаар сарын 20

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл		
1.	“Ноолуур” хөтөлбөр (2018-2021) Засгийн газрын 47 дугаар тогтоолоор батлагдсан.	Хөтөлбөрийн зорилго: Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт Гадаадын зээл, тусламж ЗГ-ын гадаа, дотоод үнэт цаас Бусад эх үүсвэрээс бүрдэнэ.		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, Гадаад харилцааны яам, БОАЖЯ, Монгол Улсын Хөгжлийн Банк, Монголын ноос, ноолуурын холбоо, олон улсын төсөл /ШХА-ийн Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл, АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл, Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл, НҮБ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл/, үйлдвэрлэгчид, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн		
4	Хэрэгжих хугацаа	I үе шат 2018-2019 он II үе шат 2020-2021 он		
4.	Хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх; Зорилт 2. Ямааны үүлдэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах; Зорилт 3. Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх; Зорилт 4. Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, зорилтот зах зээлд чиглэсэн ээлтэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх; Зорилт 5. Салбарын хүний нөөцийг эрэлт, шаардлагад тулгуурлан сургаж, мэргэшүүлэх замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх.		
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал, сая.төг)	Нийт- 973,283.0 үүнээс: -Улсын төсөв – 10,025.0 -МУХБанк(хөнгөлөлттэй зээл) -500,000.0 -Гадаадын төсөл, хөтөлбөрөөс- 20,845.0	
		2018 онд: Үүнд	Төсөв (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)
	Улсын төсөв	10,025.0	51.5	0.5
	МУХБ-с ААН-д олгосон зээл	200,000.0	188,200.0	94.1
	Гадаадын төслөөр	1,019.6	1,019.6	100.0
	2018 оны гүйц	211,044.6	189,271.1	89.6%

	<p>Нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (2018-2019 онд)</p>	<p>Нийт түүхий эдийн 40 хувийг дотоодын үйлдвэрийн хэрэгцээнд авч, ноолуурын үйлдвэрлэл, худалдаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн оновчтой дэмжлэг үзүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, бүрэн боловсруулалтын түвшинг ахиулах, кластерыг дэмжих, брэндийг таниулах, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог сайжруулна.</p>																																		
<p>6. 1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүү, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх.</p>		<p><i>1.1. Ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилго бүхий эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын сан байгуулах, 500 хүртэлх тэрбум төгрөгийн тогтмол эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсруулах. (Тайлант 2018 онд 200.0 тэрбумын эх үүсвэр бүрдүүлэх.)</i></p> <p>Монгол банк, МУХБ-тай хамтран ажиллаж, 200 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээнд үйлдвэрлэгчдэд МУХБ-ны эх үүсвэрээр зээл олгохоор ХХААХҮЯам болон МУХБ-ны хооронд 2018.03.13-ны өдөр 180313/06-070 дугаар бүхий “Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий нөхцөл тохирох гэрээ” –г байгуулж, нийт 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон.</p> <p>АХБ-ны Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төслийн “Нэмэлт санхүүжилт” төслөөс 3 үйлдвэрт 3.89 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 7%-ийн хүүтэйгээр хөрөнгө оруулалтад зориулан олгосон. Үр дүн: Зээлд хамрагдсан үйлдвэрүүдийн ноолуур бэлтгэлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 1.3 дахин, самнасан ноолуурын хэмжээ 1.6 дахин өсч, ноолуур боловсруулах салбарын түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин суурь түвшинд буюу 2014 онд 11.5% байсан бол 2018 оны байдлаар 35.8%-д хүрсэн.</p> <table border="1" data-bbox="635 1160 1490 1496"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2014 он (суурь)</th> <th>2015 он</th> <th>2016 он</th> <th>2017 он</th> <th>2018 он</th> <th>2018/2017 (%)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Ноолуур бэлтгэл, тн</td> <td>6,700</td> <td>7,700</td> <td>8,300</td> <td>9,000</td> <td>9,600</td> <td>106.6</td> </tr> <tr> <td>Бэлэн бүтээгдэхүүнд орсон т/эдийн хэмжээ, тн</td> <td>770</td> <td>900</td> <td>1,100</td> <td>1,270</td> <td>2,400</td> <td>188.9</td> </tr> <tr> <td>Нийт т/эдэд эзлэх хувь, %</td> <td rowspan="2">11.5</td> <td>11.7</td> <td>13.3</td> <td>14.1</td> <td>25.0</td> <td>177.3</td> </tr> <tr> <td>Суурь онтой харьцуулахад эзлэх хувь, %</td> <td>13.4</td> <td>16.4</td> <td>19.0</td> <td>35.8</td> <td>188.4</td> </tr> </tbody> </table> <p>*Эх сурвалж: Монголын ноос, ноолуурын холбооноос гаргасан судалгаанаас авав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100.0%</p> <p><i>1.4. Борлуулалт, маркетингийн цогц арга хэмжээг хөгжүүлж, гадаад худалдааг хөнгөвчлөх, өргөжүүлэх цогц арга хэмжээ авах; (Тайлант 2018 онд: Худалдаа ба хөрөнгө оруулалтын Замын зураг боловсруулах судалгаа хийсэн байна.)</i></p> <p>Худалдааг хөнгөвчлөх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр ГХЯ-наас Монгол улсын төвийн эдийн засгийн коридорын үнэлгээг хийлгэсэн байна. Мөн Дэлхийн худалдааны байгууллага /ИТС/-ын санхүүжилтээр “Худалдаа ба хөрөнгө оруулалтын замын зураг” төслөөс Ноос, ноолуурын салбарын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураг боловсруулах судалгаа хийсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p><i>1.6. Угаасан ноолуурын экспортыг багасгах чиглэлээр тарифын болон тарифын бус хязгаарлалт хийх асуудлыг судлан шийдвэрлэх; (Тайлант 2018 онд: ХААБ-ийн хураамжийг ноолуурын боловсруулалтын төвшинээс хамааруулан өөрчилж бодлогын зохицуулалт хийсэн байна.)</i></p>	Үзүүлэлт	2014 он (суурь)	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017 (%)	Ноолуур бэлтгэл, тн	6,700	7,700	8,300	9,000	9,600	106.6	Бэлэн бүтээгдэхүүнд орсон т/эдийн хэмжээ, тн	770	900	1,100	1,270	2,400	188.9	Нийт т/эдэд эзлэх хувь, %	11.5	11.7	13.3	14.1	25.0	177.3	Суурь онтой харьцуулахад эзлэх хувь, %	13.4	16.4	19.0	35.8	188.4
Үзүүлэлт	2014 он (суурь)	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017 (%)																														
Ноолуур бэлтгэл, тн	6,700	7,700	8,300	9,000	9,600	106.6																														
Бэлэн бүтээгдэхүүнд орсон т/эдийн хэмжээ, тн	770	900	1,100	1,270	2,400	188.9																														
Нийт т/эдэд эзлэх хувь, %	11.5	11.7	13.3	14.1	25.0	177.3																														
Суурь онтой харьцуулахад эзлэх хувь, %		13.4	16.4	19.0	35.8	188.4																														

“Монгол улсын тогтвортой байдлын үзэл баримтлал 2030”-ын 2.1.3 дахь заалт болон дотоодын үйлдвэрүүдээс ирүүлсэн санал хүсэлтэд үндэслэн ХХААХҮЯ-ны Сайдын 2018 оны 06-р сарын 13-ны өдрийн 01/2240 тоот албан бичгээр “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д угаасан ноолуурын биржийн хураамжийг нэмэгдүүлж, самнасан ноолуурынхыг бууруулах саналыг хүргүүлсэн. Ингэснээр: Биржийн шимтгэл боловсруулалтын төвшнөөс хамаарахгүйгээр 0.32 хувь байсныг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 05-р сарын 31-ны өдрийн 04 тоот тогтоолоор угаасан ноолуурт 1 хувь болгон нэмэгдүүлж, самнасан ноолуурт 0.2 хувь болгон бууруулж бодлогын зохицуулалтыг хийснээр дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

Угаасан ноолуурын экспорт өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар буурч, самнасан ноолуурын экспорт 8.45 хувиар, бэлэн бүтээгдэхүүний экспорт 8.5 хувиар тус тус өссөн байна.

ХШҮ- 100 %

2018 онд: Угаасан ноолуурын экспортын хэмжээ 5000 тн хүртэл бууруулж, самнасан ноолуурын экспортыг 650 тн хүртэл нэмэгдүүллэ.

Үзүүлэлт	2018 оны		Биелэлт, %
	Төл	Гүй	
Угаасан ноолуур, тн	5000	5286.6	105.7
Самнасан ноолуур, тн	650	742.0	114.1

Өнгөрсөн оноос угаасан ноолуурын экспортын хэмжээ 122,4 тн-оор багассан боловч тайлант 2018 оны төлөвлөсөн хэмжээнээс 286.6 тн буюу 5.7 хувиар тасарсан байна.

ХШҮ-40%

1.7. Ноолуурын боловсруулалтын түвшин, өртөг шингэсэн байдлаас хамаарч 3-аас доошгүй жилийн хугацаатай эргэлтийн хөрөнгийн болон хөнгөлөлттэй нөхцөлтэй, хөрөнгө оруулалтын урт хугацаатай зээлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах.

(Тайлант 2018 онд: 15-аас доошгүй үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгосон байна.)

Монгол улсын Хөгжлийн банк нь хөгжлийн нийт 34 төслийг судалгаанд авч, үүнээс банкны тухай хууль, тус банкны зээлийн бодлого, журмын шаардлага хангасан 6 үйлдвэрт шууд зээлийн 96.6 тэрбум төгрөг, Голомт, Хаан, ХХБ, Хас, Капитрон банкуудаар дамжуулан 14 үйлдвэрт 91.6 тэрбум төгрөг, нийтдээ 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон.

-АХБ-ны “Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил” төслийн “Нэмэлт санхүүжилт” төслөөс 3 үйлдвэрт 3.89 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 7%-ийн хүүтэйгээр хөрөнгө оруулалтад зориулан олгосон.

Зээлд хамрагдсан дээрх үйлдвэрүүдийн ноолуур бэлтгэлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад түүхий ноолуур 584.2 тн (1.3 дахин), самнасан ноолуур 124.9 тн (1.6 дахин)-оор өссөн байна. Мөн самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 33.8%, ээрэх үйлдвэрлэлийнх 28.6%, сүлжих үйлдвэрлэлийнх 42.7%-иар өсч, 1570 ажлын байр шинээр нэмэгджээ. Тухайлбал Говь ХХК самнах үйлдвэрлэлийн хүчин чадлаа 21%, сүлжих үйлдвэрлэлээ 6%, оёмол үйлдвэрлэлээ 50%-иар, Гоёо ХХК нь ээрэх, сүлжих үйлдвэрийнхээ хүчин чадлаа 3-4 дахин, Могол ноос ХХК нь ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадлаа 1,5 дахин, оёмол үйлдвэрлэлийн хүчин чадал 8 дахин нэмэгдүүлсэн байна.

Ханбогд кашимер ХХК бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэхээр 5900 мкв талбайтай 2 давхар үйлдвэрийн барилгыг барьж байна.

		<p>Говь ХК жилд 2000 тн ноолуур самнах хүчин чадалтай, анхан шатны үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн суманд байгуулахаар 17 га газар авч, шав тавих ёслолыг 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хийлээ. Энэхүү бүтээн байгуулалтын хүрээнд 1000 ажилчдын орон сууцыг эхлүүлэхээр төлөвлөсөн байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
Зорилт 1-ийн дундаж үнэлгээ -83.5%		
<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Ямааны үүлдэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах арга хэмжээ авсан байна.</p>		<p><i>2.5. Түүхий эдийн бэлтгэлийг тогтвортой байлгах зорилгоор бэлээр хамгаалах, нөхөн сэргээлт хийх, ойжуулах, усжуулах, хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчид, малчдын оролцоотой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг дэмжих;</i></p> <p>Түүхий эдийг чанар, хадгалалт, хүлээн авалтыг сайжруулах зорилгоор ШХА-ын Ногоон алт-малын эрүүл мэнд төслийн 240 сая төгрөгийн санхүүжилтээр Өвөрхангай аймагт-3, Хөвсгөлд-3, Хэнтийд-1, Баян-Өлгийд-3, нийт 10 түүхий эдийн агуулахыг ашиглалтанд оруулсан байна.</p> <p>Эдгээр агуулахыг ашиглалтад оруулснаар түүхий эдийг бэлтгэх, хадгалах, нөөцлөхөд чухал алхам болсон.</p> <p>Баялаг Өлзий компани нь Баянхонгор аймгийн Баянговь сумын малчдын түүхий эдийг тогтвортойгоор бэлтгэх зорилгоор тус сумын “Наадам” цэцэрлэгт хүрээлэнгийн 1,5 га газрыг тохижуулах, цэцэрлэгжүүлэх ажлыг мөн бэлчээр хамгаалах зорилгоор 10 га газрыг малчидтай хамтран хаших ажлыг зохион байгуулж байна. Нийт 200 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>ХХААХҮЯ-ны захиалгаар ШУТ сангийн 42,1 сая төгрөгийн санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Жинст мөрөн компани, Хөвсгөл аймгийн Бэлчээр ашиглалтын холбоо хамтран Төмөрбулаг, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Улаан-Уул, Түнэл сумдын малчидтай хамтран “Богино ширхэгтэй ноолуураар ээрмэл үйлдвэрлэх технологийн шийдэл” сэдэвт төслийг 2016-2018 онд хэрэгжүүлсэн.</p> <p>Энэхүү төслийн хүрээнд бага насны ямааны ноолуурыг тусгайлан ангилан ялгаж бэлтгэх, ноолуурын чанарын үзүүлэлтийг гарал үүсэл, бүс нутгийн ялгаагаар харьцуулан судалж, боловсруулалтын технологийн горим тогтоох судалгааг явуулж, үүний үр дүнд нь борлонгийн ноолууран ээрмэл үйлдвэрлэх зорилготой.</p> <p>Төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн дээрх сумдын малчдад 1-3 настай ямааны ноолуурыг тусгайлан бэлтгэх сургалтыг явуулсаны үр дүнд 13,5-15,5 мкм нарийнтай борлонгийн ноолуурыг бэлтгэж, 26/2 номерын ээрмэлийг үйлдвэрлэсэн. Энэхүү нарийн ширхэгтэй ээрмэл нь “Монголын хаан ширхэгт” брэндийн шалгуурыг хангаж, тус брэндийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд загвар болж байгаа юм.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>
Зорилт 2-ын дундаж үнэлгээ -70.0%		
<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлсэн байна.</p>		<p><i>3.1. Хувийн хөрөнгө оруулалтаар ээрмэлийн үйлдвэр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөжүүлэх;</i> <i>(Тайлант 2018 онд: Ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 0.4 дахин өссөн байна.)</i></p> <p>Тус 2018 онд ноолуурын үйлдвэрлэлд эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгосны үр дүнд: Самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 33.8%, ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 28.6%, сүлжих үйлдвэрийн хүчин чадал 42.7%-иар тус тус өсч, нийтдээ 1570 гаруй ажлын байр шинээр нэмэгдсэн байна.</p> <p>Ноолуурын нийт экспорт 2018 онд өмнөх оноос 21.2 хувиар буюу 68.3 сая доллараар өссөн байна.</p>

Үзүүлэлт		2017 он		2018 он	
		Тоо хэмжээ	Үнийн дүн (сая.дол)	Тоо хэмжээ	Үнийн дүн (сая.дол)
экспорт	Угаасан ноолуур	5409 тн	205.6	5286.6 тн	251.9
	Самнасан ноолуур	581.1 тн	38.5	630.2 тн	54.9
	Эцсийн бүтээгдэхүүн	648.0 шир	77.8	742.0	83.4
Нийт экспорт			321.9		390.2
Дотоод борлуулалт		693.0	63.1	858.0	64.7
Нийт борлуулалт (1.2 их наяд төгрөг)			385.0		454.9

* Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллээс авав.

Гаалийн ерөнхий газрын 2018 оны статистик мэдээгээр Нэхмэлийн салбарын (ноос, ноолуурын) нийт экспорт 409 сая ам долларт хүрч, өмнөх онтой харьцуулахад 18.2%-иар өссөн ба угаасан ноолуурын экспорт өмнөх оноос 2.3%-иар буурч, самнасан ноолуурын экспорт 8.45%-иар, бэлэн бүтээгдэхүүний экспорт 8.5%-иар тус тус нэмэгдсэн.

Нэхмэлийн салбарын экспорт



ХШҮ-100%

3.4. Ноолуурын бэлтгэл, чанар, стандарт, технологийн сургалт, үзэсгэлэн худалдаа, технологи дамжуулалт болон бусад үйлчилгээг мэргэжлийн холбоогоор гэрээгээр гүйцэтгүүлэх, үр дүнг жил бүр дүгнэж үйлдвэрлэгчид, малчдад мэдээлэх.

(2018 онд: Мэргэжлийн холбоогоор 2-оос доошгүй ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн байна.)

Монголын ноос ноолуурын холбоо (МННХ), Италийн худалдааны агентлаг (ИХА), Италийн нэхмэлийн үйлдвэрлэлийн үндэсний холбоо /ИНҮҮХ/ хамтран “Нэхмэлийн технологи дамжуулах төв”-ийг МННХ-ны дэргэд байгуулахад дэмжин ХХААХҮЯ болон Итали улсын Эдийн засаг хөгжлийн яамны хооронд Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

ХХААХҮЯ-ны эзэмшдэг “Монголын Хаан Ширхэгт” ноос, ноолуурын чанарын тэмдгийг олгох үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр ХХААХҮ-ийн Сайдын А-167 тоот тушаалаар МННХ-той 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр 181018/06-400 тоот гэрээг байгуулан, хамтран ажиллаж байна.

Монголын ноос, ноолуурын үйлдвэрлэгчдийг Япон улсын Токио хотноо зохион байгуулагддаг “Fashion World Tokyo” үзэсгэлэнд оролцуулах ажлыг зохион байгуулуулахаар МННХ-той гэрээ хийж, ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны А404 тоот тушаалаар 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

“Монгол экспорт экспо” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахаар МННХолбоо, Арьс, ширний үйлдвэрлэлийн холбоо, Мишээл экспо ХХК-тай хамтран ажиллаж, тус арга хэмжээнд зориулж ТНБД-ын 2018 оны А460 тоот тушаалаар 28 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

		<p>Үйлдвэрлэлийг дэмжих хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үйлдвэрлэлийг дэмжих сангийн дэмжлэгт хамрагдах шалгуур хангасан ноос, ноолуурын үйлдвэрүүдийн судалгааг гаргах ажлыг ТНБД-ын 2018 оны А-575 тушаалаар 8.5 сая төгрөгөөр Монголын ноос, ноолуурын холбоотой гэрээ хийж, гүйцэтгүүлсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
Зорилт 3-ын дундаж үнэлгээ -100.0%		
<p>4-р зорилтын хүрээнд: Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, зорилтот зах зээлд чиглэсэн ээлтэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх</p>		<p><i>4.1. Монгол ноолуурын өнгө, давуу шинж чанарт тулгуурлан “Монголын Хаан Ширхэгт” брэндийг хөгжүүлж, зах зээлд таниулах, сурталчлах;</i> (2018 онд:ХХААХҮЯ-ны эзэмшдэг “Монголын Хаан Ширхэгт” гэрчлэх тэмдгийг олгох байгууллагатай гэрээ хийх, суртчилах ажлууд хийгдсэн байна.)</p> <p>Монголын оюуны өмчийн газрын 10876 дугаартай ХХААХҮЯ эзэмшдэг “Монголын Хаан Ширхэгт” “ноос, ноолуурын чанарын тэмдгийг дэлхийн 33 улсын Оюуны өмчийн газарт хамгаалалтад бүртгүүлсэн. Тус гэрчлэх тэмдгийг олгох үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр ХХААХҮСайдын А-167 тоот тушаалын дагуу 181018/06-400 тоот гэрээг МННХ-той 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан.</p> <p>Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил” төсөлтэй хамтран “Монголын хаан ширхэгт” гэрчлэх тэмдгийг баталгаажуулах тогтолцоонд оролцогч талууд /ХХААХҮЯ, Монголын ноос ноолуурын холбоо, Стандартчилал хэмжилзүйн газар, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Үйлдвэрлэгчид/-ын хамтарсан уулзалт зөвөлгөөнийг зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p><i>4.2.Байгаль орчинд ээлтэй шинэ, дэвшилтэт техник, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлж, олон улсын чанар, аюулгүйн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;</i> (2018 онд: 2-оос доошгүй үйлдвэр олон улсын сертификат авсан байна.)</p> <p>Олон улсын чанарын “Оеко-Тех 100” сертификатын шалгуурыг Сор кашмир, Снөү филдс ХХК-иуд хангаж, ээрмэл утсандаа тус сертификатыг авснаараа олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлсэн.</p> <p>Ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрүүдээс гарч буй технологийн хаягдал усны хэмжээг бууруулах зорилгоор “Технологийн хаягдал усыг дамжлага бүрээр гаргах, хаягдал усаа эргүүлэн ашиглаж байгаа талаарх судалгаа”-ны ажлыг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгээр гэрээгээр гүйцэтгүүлсэн. Технологийн хаягдал усаа 85% хүртэл цэвэршүүлэн эргүүлэн ашиглаж байгаа үйлдвэрийн дэвшилтэт технологийг “Технологи дамжуулах” хуулийн хүрээнд бусад үйлдвэрт дамжуулах ажлыг дэмжихээр төлөвлөж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p><i>4.4 "Олон улсын зах зээлд ноолууран бүтээгдэхүүнийг таниулах, сурталчлах зорилтот үзэсгэлэн яармаг, бизнес форумд оролцох, зохион байгуулах; (Экспортын өсөлт 20%-аас багагүй байна.)</i></p> <p>Япон улсын Токио хотноо зохион байгуулагддаг “Fashion World Tokyo”, АНУ-ын Нью Йорк хотноо зохион байгуулагддаг “Fashion Coterie” олон улсын үзэсгэлэнд 2, 10 дугаар саруудад ноос, ноолуурын үйлдвэрүүдийг “Mongolian Cashmere” нэгдсэн нэрийн дор зохион байгуулж оролцуулахад МННХ-той хамтран ажилласан ба тус улсуудад гаргаж буй экспортын хэмжээ өмнөх онтой</p>

харьцуулахад 20-30% нэмэгдсэн байна. Мөн дотооддоо “Монгол экспорт экспо” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 40 гаруй аж ахуйн нэгжийг оролцуулсан ба энэ үеэр 180 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн экспортыг нэмэгдүүлэх зорилгоор бизнес стратегийн төлөвлөлт, үйлдвэрлэлийн менежментийн шинэчлэл, бүтээгдэхүүний чанарын туршилт болон гэрчилгээ авах, бүтээгдэхүүн нэвтрүүлэлт, экспортын яармаг, үзэсгэлэн худалдаад оролцохтой холбоотой зөвшөөрөгдсөн зардлуудыг “Экспортыг дэмжих” төслийн санхүүжилтээр олгосон. 2018 оны байдлаар ноос, ноолуур, нэхмэлийн 27 аж ахуйн нэгжид нийт 133 000 гаруй ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Япон, АНУ зэрэг олон улсын үзэсгэлэнд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжин оролцуулж байна. 2017 онтой харьцуулахад Япон улсад гаргасан экспортын хэмжээ 28.9%, АНУ-д гаргасан экспортын хэмжээ 67%-иар тус тус нэмэгдсэн.

Япон улсын экспорт

Бүтээгдэхүүн ий нэр төрөл	2017 он		2018 он	
	Тоо хэмжээ	Үнэ мян.ам.долл	Тоо хэмжээ	Үнэ мян.ам. долл
Угаасан ноолуур, тн	350	5	13242	109
Самнасан ноолуур,тн	1459	79	1354	97
Бэлэн бүтээгдэхүүн, ш	85981	4951	116599	6875
Нийт		5,035.80		7,080.40

АНУ-ын экспорт

Бүтээгдэхүү ний нэр төрөл	2017 он		2018 он	
	Тоо хэмжээ	Үнэ мян.ам.дол л	Тоо хэмжээ	Үнэ мян.ам. долл
Угаасан ноолуур	350	5		
Самнасан ноолуур	1414	78		
Бэлэн бүтээгдэхүү н	10962	724	31496	2458
Нийт		806.70		2,458.4

Нэхмэлийн салбарын нийт экспортын хэмжээ 2018 оны дүнгээр 409 сая ам долларт хүрч, өмнөх онтой харьцуулахад 22.2%-иар өсч, үүнээс ноолуурын салбарын нийт экспорт 390.2 сая ам.долларт хүрч, 2017 онтой харьцуулахад 21.2%-иар өссөн байна.

ХШҮ-100%

*4.5.Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн(ХҮСХХ) нэхмэлийн сорилт, судалгааны лабораторийг шинэчлэн чадавхжуулж, олон улсын түвшний сорилт баталгаажуулалт хийх түвшинд хүргэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;
(ХҮСХХ-ийн тоног төхөөрөмжийн нэр төрөл нэмэгдэж, ажиллагсадын мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна.)*

Тус хүрээлэнгийн нэхмэлийн сорилт, судалгааны лабораторийг шинэчлэн чадавхжуулж, олон улсын түвшний сорилт баталгаажуулалт хийх түвшинд хүргэх арга хэмжээний хүрээнд АХБ-ны санхүүжилтээр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн дэмжлэгээр ноос, ноолуурын ширхэгтийн SEM (Scanning electron microscopy) төхөөрөмж, мөн орчны чийглэг,

		<p>агааржуулалтыг тохируулах төхөөрөмжийг нийлүүлэхээр нээлттэй тендер зарлан нийлүүлэгч компанийг сонгон шалгаруулан гэрээ хийж, нийлүүлсэн.</p> <p>ШУТИС-ХСТ-д "Үйлдвэрлэл сургалтын загвар төв" байгуулахад тоног төхөөрөмж, программ хангамжийн дэмжлэг үзүүлэх 168,1 сая төгрөгийн нээлттэй тендер зарлан шалгарсан Пи Пи Пи ЭМ Жи Эл ХХК-тай тус төхөөрөмжийг нийлүүлэхээр гэрээ байгуулан нийлүүлсэн. ХШҮ-70%</p>
Зорилт 4-ийн дундаж үнэлгээ – 85.0%		
	<p>5-р зорилтын хүрээнд: Салбарын хүний нөөцийг эрэлт, шаардлагад тулгуурлан сургаж, мэргэшүүлэх замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх</p>	<p><i>5.3.Үйлдвэрүүд гадаад дахь ижил төрлийн үйлдвэртэй мэргэжилтэн солилцох хэлбэрээр олон улсын техник, технологийг судлах, туршлага хуримтлуулах ажлыг зохион байгуулах;</i> (Олон улсад туршлага судлах, ажилтнуудыг мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулагдсан байна.)</p> <p>Дэлхийн банкны “Экспортыг дэмжих” төслийн санхүүжилтээр АРЕХ 3-3 дизайн системийн ахисан түвшний сургалтыг ШУТИС-ийн “Шима секи” сургалтын төв, Японы Shima Seiki фирмтэй хамтран явуулж, нийт 25 үйлдвэрийн 50 гаруй дизайнерууд хамруулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлэв.</p> <p>МННХ нь Ноос, ноолуурын салбарын ИТА-дад гадаад худалдаа, экспорт, татвар эрх зүй, бизнесийн англи хэл, ур чадварын сургалт, технологийн шат дамжлага бүрээр-30 гаруй сургалтыг давхардсан тоогоор 900 гаруй ИТА-дад зохион байгуулсан.</p> <p>НҮБ-ын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн санхүүжилтээр 4 хүн Турк улсад зохион байгуулагдсан “Техникийн текстилийн олон улсын сургалт, хурал”-д оролцож, үйлдвэрүүдийн туршлага судлав. ХШҮ-100%</p>
Зорилт 5-ын дундаж үнэлгээ – 100.0%		
7.	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>1. “Ноолуур” хөтөлбөрийн 2018 оны жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 87.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв.</p> <p>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хугацаа алдаж батлуулсан ч ХХААХҮЯ-наас бодлогоор дэмжиж МУХБ-тай хамтран ажиллаж, гэрээ байгуулснаар ноолуурын үйлдвэрлэлийг дэмжихээр эргэлтийн хөрөнгийн 188.2 тэрбум төгрөгийн зээл олгосон нь маш том дэмжлэг болсон. Үүний үр дүнд самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 33.8, ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 28.6, сүлжих үйлдвэрийн хүчин чадал 42.7 хувиар тус тус өсч, нийтдээ 1570 гаруй ажлын байр шинээр нэмэгдсэн байна.</p> <p>3. Тайлант 2018 онд бэлтгэсэн ноолуур нь нийт түүхий эдийн 25 хувийг эзэлж байгаа нь хөтөлбөрийн I шатанд (2018-2019он) нийт түүхий эдийн 40 хувийг дотоодын үйлдвэрийн хэрэгцээнд авч бэлтгэх гэсэн зорилтын 62.5 хувийг эзэлж байгаагаас үзэхэд энэхүү зорилт хэрэгжих боломжтой гэж дүгнэж байна.</p> <p>Ололттой тал:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Монгол банк, МУХБ-тай хамтран ажиллаж, 200 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлсэн. ХХААХҮЯам болон МУХБ-ны хооронд 2018.03.13-ны өдөр 180313/06-070 дугаар бүхий “Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий нөхцөл тохирох гэрээ”-г байгуулж, 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгосон. ➤ Ноос, ноолуурын салбарын судалгаа хийгдсэн байна. ➤ Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, экспортод гаргах зорилгоор “Монгол экспорт экспо”

		<p>нэгдсэн арга хэмжээг МННХолбоо, Арьс, ширний үйлдвэрлэлийн холбоо, Мишээл экспо ХХК-тай хамтран зохион байгуулсан.</p> <p>Дутагдалтай тал, түлгамдсан асуудал:</p> <p>➤ ҮСХ-ноос гаргаж буй мэдээгээр ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалтын мэдээ нэр төрлөөр /угаасан, самнасан, бэлэн бүтээгдэхүүн/ үнэн зөв гардаггүй тул хөтөлбөрийг дүгнэхэд албан мэдээ байхгүй байна.</p> <p>➤ Үйлдвэрлэлт, дотоодын борлуулалтыг мэдээг МННХолбооноос авдаг. Мэдээг тогтмол шинэчилж чаддаггүй.</p>						
8.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хөтөлбөрөөс Сангийн яам, Гадаад харилцааны яам, БОАЖЯ, МУХБанк, Монголын ноос, ноолуурын холбоо, олон улсын төсөл /ШХА-ийн Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл, АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл, Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл, НҮБ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл/, үйлдвэрлэгчид, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн зэрэг хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа холбоог “Хангалттай” гэж үнэлж байна.						
9.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		87.7 %	5	83.5	70	100	85.0	100
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %						

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ
(2018 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017 он)	2018 оны гүйцэтгэл	Зорилтот түвшин (2021 он)
1.	Угаасан ноолуурын экспорт	тн	5409.7	5286.6	2632
2.	Самнасан ноолуурын экспорт	тн	571.4	630.2	1579
3.	Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлт	мя.ш	915.6	932.5	2200
4.	Ажлын байрны тоо (байнгын)	хүн	5582	7126	9110

ЗӨВЛӨМЖ

- Цаашид ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
- Хөгжлийн банк нь ХХААХҮЯамтай байгуулсан гэрээний дагуу үүргээ биелүүлж, эргэлтийн хөрөнгийн зээлийн дэмжлэгийг ноолуур бэлтгэлийн хугацаанаас өмнө олгох, хугацааг сунгах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
- Угаасан ноолуурын экспортыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах. Үүнд:НӨАТатвар ногдуулах, техникийн зохицуулалт хийх/экспортод гарч буй ноолуурт самнасан ноолуурын стандартыг тавих,
- Хөнгөн үйлдвэрийн /ноос, ноолуур, арьс шир, оёдол г.м/ салбарын бодит статистик мэдээлэлтэй болох чиглэлээр ҮСХ-той хамтран ажилах,
- Хөнгөн үйлдвэрийн нэгдсэн мэдээллийн сантай болохыг ХөнҮБХЗГ-т зөвлөж байна.

НООЛУУР ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	Хийгдэх үйл ажиллагаа	2018 оны		ХШҮ, хувиар
			Хүрэх үр дүн	Биелэлт	
Зорилт 1. Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх					
1.1	Ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилго бүхий эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын сан байгуулах, 500 хүртэлх тэрбум төгрөгийн тогтмол эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсруулах	Монгол банк, Монгол Улсын Хөгжлийн банктай хамтран ажиллаж зээлийн санг бүрдүүлэх	200.0 тэрбум төгрөгийн зээлийн сан бүрдүүлэх	Монгол банк, МУХБ-тай хамтран ажиллаж, 200 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлсэн. “Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэгчдэд Хөгжлийн банкны эх үүсвэрээр зээл олгохоор ХХААХҮЯ болон Монгол улсын Хөгжлийн банкны хооронд 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 180313/06-070 дугаар бүхий “Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий нөхцөл тохирох гэрээ” –г байгуулсан. МУХБ нь нийт 34 төслийг судалгаанд авч, үүнээс банкны тухай хууль, тус банкны зээлийн бодлого, журмын шаардлага хангасан 6 үйлдвэрт шууд зээлийн 96.6, Голомт, Хаан, ХХБ, Хас, Капитрон банкуудаар дамжуулан 14 үйлдвэрт 91.6, нийт 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон. -Мөн АХБ-ны Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төслийн “Нэмэлт санхүүжилт” төслөөс 3 үйлдвэрт 3.89 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 7%-ийн хүүтэйгээр хөрөнгө оруулалтад зориулан олгосон.	94.1
1.2	Ноолуурын анхан шатны боловсруулалтыг төр, хувийн хэвшлийн хяналттай болгох чиглэлээр аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах	Ноос, ноолуурын салбарын судалгаа хийгдсэн байна.	Үйлдвэрлэлийг дэмжих хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үйлдвэрлэлийг дэмжих сангийн дэмжлэгт хамрагдах шалгуур хангасан ноос, ноолуурын үйлдвэрүүдийн судалгааг гаргах ажлыг ТНБД-ын 2018 оны А-575 тушаалаар 8.5 сая төгрөгөөр Монголын ноос, ноолуурын холбоотой гэрээ хийж, гүйцэтгүүлсэн.	100.0
1.3	Борлуулалт, маркетингийн цогц арга хэмжээг хөгжүүлж, гадаад худалдааг хөнгөвчлөх, өргөжүүлэх арга хэмжээ авах	Худалдаа ба хөрөнгө оруулалтын Замын зураг боловсруулах, Гадаад худалдааг	Худалдаа ба хөрөнгө оруулалтын Замын зураг боловсруулах судалгаа хийсэн байна.	Худалдааг хөнгөвчлөх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр ГХЯ-наас Монгол улсын төвийн эдийн засгийн коридорын үнэлгээг хийлгэсэн байна. Мөн Дэлхийн худалдааны байгууллага /ИТС/-ын санхүүжилтээр “Худалдаа ба хөрөнгө оруулалтын замын зураг” төслөөс Ноос, ноолуурын салбарын	100.0

		өргөжүүлэх чиглэлээр зорилтот зах зээлийн судалгаа хийх		худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураг боловсруулах судалгаа хийсэн.															
1.4	Угаасан ноолуурын экспортыг багасгах чиглэлээр тарифын болон тарифын бус хязгаарлалт хийх асуудлыг судлан шийдвэрлэ	Экспортод гаргасан угаасан ноолуурт НӨАТ-ийн татвар ногдуулах асуудлыг судлан шийдвэрлэх	Угаасан ноолуурын экспортын хэмжээ 5000 тн хүртэл бууруулж, самнасан ноолуурын экспортыг 650 тн хүртэл нэмэгдүүлнэ.	<table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">Үзүүлэлт</th> <th colspan="2">2018 оны</th> <th rowspan="2">Биелэлт, %</th> </tr> <tr> <th>Төл</th> <th>Гүй</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Угаасан ноолуур, тн</td> <td>5000</td> <td>5286.6</td> <td>105.7</td> </tr> <tr> <td>Самнасан ноолуур, тн</td> <td>650</td> <td>742.0</td> <td>114.1</td> </tr> </tbody> </table> <p>Өнгөрсөн оноос угаасан ноолуурын экспортын хэмжээ 122,4 тн-оор багассан боловч тайлант 2018 оны төлөвлөсөн хэмжээнээс 286.6 тн буюу 5.7 хувиар тасарсан байна.</p>	Үзүүлэлт	2018 оны		Биелэлт, %	Төл	Гүй	Угаасан ноолуур, тн	5000	5286.6	105.7	Самнасан ноолуур, тн	650	742.0	114.1	40.0
Үзүүлэлт	2018 оны		Биелэлт, %																
	Төл	Гүй																	
Угаасан ноолуур, тн	5000	5286.6	105.7																
Самнасан ноолуур, тн	650	742.0	114.1																
1.5	Ноолуурын боловсруулалтын түвшин, өртөг шингэсэн байдлаас хамаарч 3-аас доошгүй жилийн хугацаатай эргэлтийн хөрөнгийн болон хөнгөлөлттэй нөхцөлтэй, хөрөнгө оруулалтын урт хугацаатай зээлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах	Ноолуурын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зориулалтаар олгогдсон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг олгоно.	10.0 тэрбум төгрөгийг олгоно.	2018 оны улсын төсөвт батлагдаагүй болно.	ҮБ-гүй														
Зорилт 1-ийн биелэлт					83.5														
Зорилт 2: Ямааны үүлдэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах																			
2.1	Түүхий эдийн бэлтгэлийг тогтвортой байлгах зорилгоор бэлчээр хамгаалах, нөхөн сэргээлт хийх, ойжуулах, усжуулах, хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчид, малчдын оролцоотой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг дэмжих	Малчид, үйлдвэрлэгчдийн хамтарсан төсөл, хөтөлбөрийн санаачлагыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх		-Баялаг Өлзий компани нь Баянхонгор аймгийн Баянговь сумын малчдын түүхий эдийг тогтвортойгоор бэлтгэх зорилгоор тус сумын “Наадам” цэцэрлэгт хүрээлэнгийн 1,5 га газрыг тохижуулах, цэцэрлэгжүүлэх ажлыг мөн бэлчээр хамгаалах зорилгоор 10 га газрыг малчидтай хамтран хаших ажлыг зохион байгуулж байна. Нийт 200 сая төгрөгийг зарцуулсан байна. -ХХААХҮЯ-ны захиалгаар ШҮТ сангийн 42,1 сая төгрөгийн санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Жинст мөрөн компани, Хөвсгөл аймгийн Бэлчээр ашиглалтын холбоо хамтран Төмөрбулаг, Арбулаг, Алаг-	70														

				<p>Эрдэнэ, Улаан-Уул, Түнэл сумдын малчидтай хамтран “Богино ширхэгттэй ноолуураар ээрмэл үйлдвэрлэх технологийн шийдэл” сэдэвт төслийг 2016-2018 онд хэрэгжүүлсэн.</p> <p>- Түүхий эдийн чанар, хадгалалт, хүлээн авалтыг сайжруулах зорилгоор ШХА-ын Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн 240 сая төгрөгийн санхүүжилтээр Өвөрхангай аймагт-3, Хөвсгөлд-3, Хэнтийд-1, Баян-Өлгийд-3, нийт 10 түүхий эдийн агуулахыг ашиглалтанд оруулсан байна.</p>	
Зорилт 2-ын дүн					70.0
Зорилт.3. Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх					
3.1	Хувийн хөрөнгө оруулалтаар ээрмэлийн үйлдвэр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөжүүлэх	Ээрмэл үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд үйлдвэрлэгчдийг дэмжих	Ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 0.4 дахин өссөн байна.	<p>Ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 2018 онд 120 тн-оор нэмэгдсэн байна.</p> <p>Гоёо ХХК ээрэх үйлдвэрлэл хүчин чадлаа 3.6 дахин нэмэгдүүлсэн.</p> <p>Ээрэх үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал 0.7 дахин нэмэгдсэн байна.</p>	100
3.2	Ноолуурын бэлтгэл, чанар, стандарт, технологийн сургалт, үзэсгэлэн худалдаа, технологи дамжуулалт болон бусад үйлчилгээг мэргэжлийн холбоогоор гэрээгээр гүйцэтгүүлэх, үр дүнг жил бүр дүгнэж үйлдвэрлэгчид, малчдад мэдээлэх	Дотоодын уламжлалт үзэсгэлэн худалдааг мэргэжлийн холбоогоор гэрээгээр гүйцэтгүүлэх, сургалт, семинарыг мэргэжлийн холбоод болон бусад талуудтай хамтран зохион байгуулах	<p>-Монгол экспорт экспо нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан байна.</p> <p>-Мэргэжлийн холбоогоор 2-оос доошгүй ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн байна.</p>	<p>Монголын ноос ноолуурын холбоо (МННХ), Италийн худалдааны агентлаг (ИХА), Италийн нэхмэлийн үйлдвэрлэлийн үндэсний холбоо /ИНҮҮХ/ хамтран “Нэхмэлийн технологи дамжуулах төв”-ийг МННХ-ны дэргэд байгуулахад дэмжин ХХААХҮЯ болон Итали улсын Эдийн засаг хөгжлийн яамны хооронд Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.</p> <p>ХХААХҮЯ-ны эзэмшдэг “Монголын Хаан Ширхэгт” ноос, ноолуурын чанарын тэмдгийг олгох үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр ХХААХҮ-ийн Сайдын А-167 тоот тушаалаар МННХ-той 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр 181018/06-400 тоот гэрээг байгуулан, хамтран ажиллаж байна.</p> <p>Монголын ноос, ноолуурын үйлдвэрлэгчдийг Япон улсын Токио хотноо зохион байгуулагддаг “Fashion World Tokyo” үзэсгэлэнд оролцуулах ажлыг зохион байгуулуулахаар МННХ-той гэрээ хийж, ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны А404 тоот тушаалаар 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>“Монгол экспорт экспо” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахаар МННХолбоо, Арьс, ширний үйлдвэрлэлийн холбоо, Мишээл экспо ХХК-тай хамтран ажиллаж, тус арга</p>	100

				<p>хэмжээнд зориулж ТНБД-ын 2018 оны А460 тоот тушаалаар 28 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Үйлдвэрлэлийг дэмжих хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үйлдвэрлэлийг дэмжих сангийн дэмжлэгт хамрагдах шалгуур хангасан ноос, ноолуурын үйлдвэрүүдийн судалгааг гаргах ажлыг ТНБД-ын 2018 оны А-575 тушаалаар 8.5 сая төгрөгөөр Монголын ноос, ноолуурын холбоотой гэрээ хийж, гүйцэтгүүлсэн.</p>	
Зорилт 3-ын биелэлт					100.0
Зорилт 4. Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, зорилтот зах зээлд чиглэсэн ээлтэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх					
4.1	Монгол ноолуурын өнгө, давуу шинж чанарт тулгуурлан “Монголын Хаан Ширхэгт” брэндийг хөгжүүлж, зах зээлд таниулах, сурталчлах	“Монголын Хаан Ширхэгт” бүтээгдэхүүнд гэрчлэх тэмдэг олгогдож, зах зээлд сурталчлан таниулах	Монголын Хаан Ширхэгт” бүтээгдэхүүнд гэрчлэх тэмдэг олгогдож, зах зээлд сурталчлан таниулах арга хэмжээ зохион байгуулагдсан байна.	<p>Монголын оюуны өмчийн газрын 10876 дугаартай ХХААХҮЯ эзэмшдэг “Монголын Хаан Ширхэгт” “ноос, ноолуурын чанарын тэмдгийг дэлхийн 33 улсын Оюуны өмчийн газарт хамгаалалтад бүртгүүлсэн. Тус гэрчлэх тэмдгийг олгох үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр ХХААХҮСайдын А-167 тоот тушаалын дагуу 181018/06-400 тоот гэрээг МННХ-той 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан.</p> <p>Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төсөлтэй хамтран “Монголын хаан ширхэгт” гэрчлэх тэмдгийг баталгаажуулах тогтолцоонд оролцогч талууд /ХХААХҮЯ, Монголын ноос ноолуурын холбоо, Стандартчилал хэмжилзүйн газар, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Үйлдвэрлэгчид/-ын хамтарсан уулзалт зөвөлгөөнийг зохион байгуулсан.</p>	70
4.2	Байгаль орчинд ээлтэй шинэ, дэвшилтэт техник, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлж, олон улсын чанар, аюулгүйн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Органик бүтээгдэхүүнийг ялгах тэмдэг, чанарын сертификатжуулах ажлыг дэмжсэн байна.	2-оос доошгүй үйлдвэр олон улсын сертификат авсан байна.	<p>-Олон улсын чанарын “Oeko-Tex 100” сертификатын шалгуурыг Сор кашмир, Снөү филдс ХХК-иуд хангаж, ээрмэл утсандаа тус сертификатыг авснаараа олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүллээ.</p> <p>-Ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрүүдээс гарч буй технологийн хаягдал усны хэмжээг бууруулах зорилгоор “Технологийн хаягдал усыг дамжлага бүрээр гаргах, хаягдал усаа эргүүлэн ашиглаж байгаа талаарх судалгаа”-ны ажлыг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгээр гэрээгээр гүйцэтгүүлсэн. Технологийн хаягдал усаа 85%</p>	100

				хүртэл цэвэршүүлэн эргүүлэн ашиглаж байгаа үйлдвэрийн дэвшилтэт технологийг “Технологи дамжуулах” хуулийн хүрээнд бусад үйлдвэрт дамжуулах ажлыг дэмжихээр төлөвлөж байна.	
4.3	"Олон улсын зах зээлд ноолууран бүтээгдэхүүнийг таниулах, сурталчлах зорилгот үзэсгэлэн яармаг, бизнес форумд оролцох, зохион байгуулах;	Экспортын хэмжээ нэмэгдсэн байна. /2017 оны экспорт- 321 сая ам доллар	Экспортын өсөлт 20%-аас багагүй байна.	<p>-Япон улсын Токио хотноо зохион байгуулагддаг “Fashion World Tokyo”, АНУ-ын Нью Йорк хотноо зохион байгуулагддаг “Fashion Coterie” олон улсын үзэсгэлэнд 2, 10 дугаар саруудад ноос, ноолуурын үйлдвэрүүдийг “Mongolian Cashmere” нэгдсэн нэрийн дор зохион байгуулж оролцуулахад МННХ-той хамтран ажилласан ба тус улсуудад гаргаж буй экспортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 20-30% нэмэгдсэн байна. Мөн дотооддоо “Монгол экспорт экспо” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 40 гаруй аж ахуйн нэгжийг оролцуулсан ба энэ үеэр 180 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p>-Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн экспортыг нэмэгдүүлэх зорилгоор бизнес стратегийн төлөвлөлт, үйлдвэрлэлийн менежментийн шинэчлэл, бүтээгдэхүүний чанарын туршилт болон гэрчилгээ авах, бүтээгдэхүүн нэвтрүүлэлт, экспортын яармаг, үзэсгэлэн худалдаад оролцохтой холбоотой зөвшөөрөгдсөн зардлуудыг “Экспортыг дэмжих” төслийн санхүүжилтээр олгосон. 2018 оны байдлаар ноос, ноолуур, нэхмэлийн 27 аж ахуйн нэгжид нийт 133 000 гаруй ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- Нэхмэлийн салбарын нийт экспортын хэмжээ 2018 оны дүнгээр 409 сая ам долларт хүрч, өмнөх онтой харьцуулахад 22.2%-иар өссөн байна.</p>	100



				<p>Ноолуурын салбарын нийт экспорт 390.2 сая ам.долларт хүрч, 2017 онтой харьцуулахад 21.2%-иар өссөн ба угаасан ноолуурын экспорт өмнөх оноос 2.3%-иар буурч, самнасан ноолуурын экспорт 8.45%-иар, бэлэн бүтээгдэхүүний экспорт 8.5%-иар тус тус нэмэгдсэн байна.</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Үзүүлэлт</th> <th colspan="2">2017 он</th> <th colspan="2">2018 он</th> </tr> <tr> <th>Тоо, хэмжээ</th> <th>Үнийн дүн /сая.долл/</th> <th>Тоо, хэмжээ</th> <th>Үнийн дүн /сая.долл/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="4">1</td> <td>Угаасан ноолуур</td> <td>5409 тн</td> <td>205.6</td> <td>5288.6тн</td> <td>251.9</td> </tr> <tr> <td>Самнасан ноолуур</td> <td>581.1 тн</td> <td>38.5</td> <td>630.2тн</td> <td>54.9</td> </tr> <tr> <td>Эцсийн бэлэн бүтээгдэхүүн шир</td> <td>648.0</td> <td>77.8</td> <td>742.0</td> <td>83.4</td> </tr> <tr> <td>Нийт экспорт</td> <td></td> <td>321.9</td> <td></td> <td>390.2</td> </tr> <tr> <td>2</td> <td>Дотоод борлуулалт</td> <td>693.0</td> <td>63.1</td> <td>858.0</td> <td>64.7</td> </tr> <tr> <td></td> <td>Нийт борлуулалт /1.2 их наяд төгрөг/</td> <td></td> <td>385.0</td> <td></td> <td>454.9</td> </tr> </tbody> </table>	№	Үзүүлэлт	2017 он		2018 он		Тоо, хэмжээ	Үнийн дүн /сая.долл/	Тоо, хэмжээ	Үнийн дүн /сая.долл/	1	Угаасан ноолуур	5409 тн	205.6	5288.6тн	251.9	Самнасан ноолуур	581.1 тн	38.5	630.2тн	54.9	Эцсийн бэлэн бүтээгдэхүүн шир	648.0	77.8	742.0	83.4	Нийт экспорт		321.9		390.2	2	Дотоод борлуулалт	693.0	63.1	858.0	64.7		Нийт борлуулалт /1.2 их наяд төгрөг/		385.0		454.9	
№	Үзүүлэлт	2017 он		2018 он																																												
		Тоо, хэмжээ	Үнийн дүн /сая.долл/	Тоо, хэмжээ	Үнийн дүн /сая.долл/																																											
1	Угаасан ноолуур	5409 тн	205.6	5288.6тн	251.9																																											
	Самнасан ноолуур	581.1 тн	38.5	630.2тн	54.9																																											
	Эцсийн бэлэн бүтээгдэхүүн шир	648.0	77.8	742.0	83.4																																											
	Нийт экспорт		321.9		390.2																																											
2	Дотоод борлуулалт	693.0	63.1	858.0	64.7																																											
	Нийт борлуулалт /1.2 их наяд төгрөг/		385.0		454.9																																											
4.4	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн нэхмэлийн сорилт, судалгааны лабораторийг шинэчлэн чадавхжуулж, олон улсын түвшний сорилт баталгаажуулалт хийх түвшинд хүргэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;	Хөнгөн үйлдвэрийн хүрээлэнгийн тоног төхөөрөмжийн нэр төрөл нэмэгдэж, ажиллагсадын мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна.	Тоног төхөөрөмжийн нэр төрөл нэмэгдсэн байна.	<p>АХБ-ны санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнд ноос, ноолуурын ширхэгтийн SEM (Scanning electron microscopy) төхөөрөмжийг нийлүүлэхээр 508,2 сая төгрөгийн тендэр зарлан, тендэрт шалгарсан Пи Пи Пи ЭМ Жи Эл ХХК-тай тус төхөөрөмжийг нийлүүлэхээр 181210/07-533 тоот гэрээ байгуулсан. Мөн тус хүрээлэнд орчны чийглэг, агааржуулалтыг тохируулах төхөөрөмжийг нийлүүлэхээр 121.4 сая төгрөгийн нээлттэй тендэр зарлан “NEW BEST CHOICE” компанийг сонгон шалгаруулан гэрээ хийж байна.</p>	70																																											
Зорилт 4-ийн биелэлт					85.0																																											
Зорилт 5. Салбарын хүний нөөцийг эрэлт, шаардлагад тулгуурлан сургаж, мэргэшүүлэх замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх.																																																
5.3	Үйлдвэрүүд гадаад дахь ижил төрлийн үйлдвэртэй мэргэжилтэн солилцох хэлбэрээр олон улсын техник, технологийг судлах, туршлага хуримтлуулах ажлыг зохион байгуулах	Олон улсад туршлага судлах, ажилтнуудыг мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулагдсан байна.		<p>-МННХ нь Ноос, ноолуурын салбарын ИТА-дад гадаад худалдаа, экспорт, татвар эрх зүй, бизнесийн англи хэл, ур чадварын сургалт, технологийн шат дамжлага бүрээр-30 гаруй сургалтыг давхардсан тоогоор 900 гаруй ИТА-дад зохион байгуулсан.</p> <p>-Дэлхийн банкны “Экспортыг дэмжих” төслийн 35000 ам,долларын санхүүжилтээр ШУТИС-ийн “Шима секи” сургалтын төвд АРЕХ 3-3 дизайн системийн ахисан түвшний сургалтыг Японы Shima Seiki фирмийн Total Design Center-ийн</p>	100																																											

				зөвлөх Hirofumi Honda явуулж, нийт 25 үйлдвэрийн 50 гаруй дизайнерууд хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэв. -НҮБ-ын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн санхүүжилтээр 4 хүн Турк улсад зохион байгуулагдсан “Техникийн текстилийн олон улсын сургалт, хурал” оролцож, үйлдвэрүүдийн туршлага судлав.	
				Зорилт 5-ын дундаж дүн	100
				Төлөвлөгөөний биелэлтийн дундаж дүн	87.7